



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/828

Ховд

Төсөвт зохицуулалт хийх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 15 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ Ховд Жаргалант ТҮК” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ажилчдын өвлийн хувцасны үнийн урьдчилгаа төлбөрт Замын сангаас хөтөлбөр хооронд хэрэгжүүлэх 2770.0 мянган төгрөгийн зохицуулалтыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хөтөлбөр хооронд зохицуулалт хийсэн 2770.0 мянган төгрөг /хоёр сая долоон зуун далан мянган/-ийг “Шинэ Ховд Жаргалант ТҮК” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ажилчдын өвлийн хувцасны үнэд зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Зохицуулалт хийсэн төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажилчдыг стандартын хувцсаар хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг “Шинэ Ховд Жаргалант ТҮК” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга /Д.Бумцэнд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 4057
D/Zah-A/828-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 22-ны өдрийн
А/828 дугаар захирамжийн хавсралт



**“ШИНЭ ХОВД ЖАРГАЛАНТ ТҮК” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЖИЛЧДЫН ӨВЛИЙН ХУВЦАСНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

	2021 оны батлагдсан хөтөлбөр		Зарцуулагдаагүй үлдэгдэл дүн /төгрөг/	Зохицуулан зарцуулах хөтөлбөрийн нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Дүн /төгрөг/	
	Дугаар	Нэр						
1.	Замын сан	2.5	Замын тэмдэг тэмдэглэгээ /Жаргалант сум/ /Төсөв 80000.0 Гэрээ 76000.0/	2770000.00	Жаргалант ТҮК ОНӨААТҮ Г-ын ажилчдын өвлийн хувцас хос	40	181500.00	7260000.00
Дүн							7260000.00	
Үүнээс урьдчилгаа төлбөр хийх дүн							2770000.00	

-oOo-